

# Итгэлийн тунхгийг судлах үйл ажиллагаа

1-р алхам: Итгэлийн тунхгаас өнөөдөр судлахыг хүсэж буй нэг тунхгаа сонгоод, дараах асуултуудад хариул.

- Та энэ итгэлийн тунхгаас ямар мөнхийн үнэн эсвэл үнэнүүдийг олж мэдсэн бэ?
- Энэ итгэлийн тунхаг дахь сургаалууд Тэнгэрлэг Эцэг, Есүс Христ хоёртой харилцах харилцаанд тань хэрхэн нөлөөлөх вэ?

2-р алхам: Сонгосон итгэлийн тунхгийнхаа талаар илүү ихийг олж мэдэхэд тань туслах дор хаяж хоёр үйл ажиллагааг доороос сонго.

- Цээжил.* Итгэлийн тунхгаа цээжлэхэд туслах санаа бодож олж, цаг гарган цээжил.
- Холбогдох эх сурвалжуудыг ол.* Таны сонгосон итгэлийн тунхагтай холбоотой холбогдох судар, Сүмийн удирдагчдын мэдэгдлийг хайж ол. Та судар дээрх зүүлт тайлбар, Topical Guide, Судруудын удирдамж эсвэл Gospel Library аппликэйшн дээр байгаа хайлт үйлдэл зэрэг хэрэгслүүдийг ашиглаж болно.
- Үзүүлэн толилуулах материал хий.* Уран зургийг ашиглах нь сонгосон итгэлийн тунхгийнхаа сургаалуудын талаар ярихад эсвэл толилуулахад тусална. Жишээлбэл: Зураг, эвлүүлэг, үгсээр бүтээсэн зураг эсвэл мийм зэрэг байж болно. (Бурханы ариун нандин мөн чанарыг хадгалах үүднээс Бурхан Тэргүүтэнийг зурахаас зайлсхий.)
- Жишээ зохио.* Танд болон өөр өсвөр үеийнхэнд тулгарч болох ямар нөхцөл байдалд эсвэл сайн мэдээтэй холбоотой байж болох асуултад таны судлах итгэлийн тунхаг тусалж болох талаар бодож үз. Жишээ эсвэл асуултуудыг бичээд, итгэлийн тунхаг дээр заасан үнэнүүд хэрхэн, яагаад тус болж болохыг тайлбарла.
- Гэрчил.* Итгэлийн тунхаг дээр тань заасан үнэнүүдийн талаарх гэрчлэлээ бич. Эдгээр сургаал нь хэрхэн таны амьдралыг адисалж, таныг Бурхантай илүү ойр болоход тусалсан талаар тайлбарла.